

бүх талын харилцан уялдаат утга учрыг тод томруун бэлэгдэн харуулж байна.

Улаангомоос Улсын нийслэлийн зүг нисэх онгоц агаар мандалд хөөрөхөд Чандмань улаан уул улам өндөр сүрлэг, өнгө жавхаатай болж сүндэрлээд удалгүй зүүн гар талд зах хязгаар нь үл үзэгдэх Увс нуур, баруун гарт цэнгэг уст Хяргас нуур тус тус тэнгэрийн хаяанд хөхрөн цэнхэртэж, ар талд алсаас цайран гялалзагч мөнх цаст Хархираа уултай зорчигчдод орон нутгийн сайн сайхны санамж дурсгал болж үлдээд тэр бүгд нэгэн зэрэг дуу хоолойгоо нийлүүлэн, чин сэтгэлийн угаас сайн сайхныг хүсэх, ерөөх мэт байдаг байна.

МОНГОЛЧУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ УЛАМЖЛАЛААС

Т. МӨНХЦЭЦЭГ

Манай ард түмэн байгаль орчноо хамгаалах талаар олон зуун жилийн баялаг уламжлалтай билээ. Энэ нь тэдний оршин байгаа газар нутаг, цаг уур, хөтлөж буй аж ахуйн онцлогтой холбоотой юм. Монголчууд эрт цагаас мал маллан бэлчээрийн соргог, усны тунгалагийг дагаж нүүдэллэн ирсэн нь байгаль орчинтойгоо танилцах, зүй тогтлыг нь танин мэдэх улмаар түүнтэй харьцахад зохих ёсоор нөлөөлжээ. Тэрээр амьжиргааны гол үндэс болсон мал аж ахуйгаа хөтлөн явуулдаг бэлчээрээ зохистой эдлэх, нүүхдээ буйраа цэвэрлэх, үнсээ салхины дор тогтмол газар хаях зэрэг нь тэдний өдөр тутмын амьдралын хэвшил болсон байна. Манай ард түмэн усыг чандмань эрдэнэ хэмээн дээдлэн үзэж түүнийг бохирдуулах, булаг шандын эхийг хөндөх, зулзган мод огтлох, нялх ногоо, ургамлын үндсийг таслах, газар онгилж сэндийлгэх зэргийг цээрлэхийн зэрэгцээ ан амьтан, байгалийн баялагийг ашиглах талаар тодорхой мэдлэгтэй байжээ. Энэхүү хэв заншил болсон зүйлс хууль цаазанд ч тусгалаа олсон байна.

Монголчууд хууль журам батлан тогтоохдоо байгалийн баялаг түүний ашиг шимийн тухай заалтыг тогтоон мөрдүүлэх явдал одоо мэдэгдэж байгаагаар 800-гаад жилийн өмнөөс тухайлбал «Их засаг» хуулиас эхэлжээ. «Их засаг»-т усыг ямар нэг хэмжээгээр бохирдуулахад хатуу ял оноож байсан байна. Юан улсын үед өртөө, замын дагуу мод тарьж суулгадаг байжээ. Марко Поло тэмдэглэлдээ, Их хаан элч, худалдаачид хэн бүхний зорчдог замын дагуу хоёр алхам тутамд мод тарихыг тушаасан тухай, мөн хааны зарлигийн дагуу тарьсан эдгээр мод нь алсаас тодхон харагдах нь алив хүнийг төөрөхөөс сэргийлэх бөгөөд халуунд сүүдэрлэг тохиромжтой байдаг гэжээ.¹ Өлзийт хааны үед гаргасан хууль цаазын бичигт (1294) «... хавар болоход хамгийн урьд мод тарьж суулгах хэрэгтэй. .. Модыг зүй бус огтолж үл болно. Зөрчигчдийг хууль ёсоор ялласугай. Ой мод их болох аваас албан ба аминд цөм ашигтай» гэсэн байдаг.

Тэрчлэн Юан улсын хууль цаазын бичигт хун, тас, харцага, шонхор агнахыг бүрмөсөн цаазалсан нь монголчуудын байгалийг өөрөөр нь хамгаалуулах гэсэн мэдлэг ухаантай холбоотой юм. Харцага, шонхор нь бэлчээрийг сүйтгэдэг оготоно зэрэг мэрэгчдийг устгадаг бол тас амьтны сэгээр хооллодоогоороо байгаль орчныг цэвэрлэхэд үлэмж нөлөөтэй байв.

Манай түүхийн сурвалж бичигт байгалийн ашиг шимийг амьдрал ахуйдаа хэрэглэх, ан агнуурыг хэдий үед хийх талаар бичсэн байдаг. Монголчууд ангийн махыг хүнсэнд хэрэглэхийн зэрэгцээ үс арьсыг нь ашиглан дээл, хувцас хийн өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг байжээ. Тэрээр ан амьтныг тарга хүчээ авч, үс нь ургаж гүйцсэн үед тусгай тогтосон хугацаанд агнах журамтай байсан ба ангийн хээл томорсон үеэс төллөх үед агналтыг зогсоож илтэй согоо, хотолтой сүндэс, янзгатай зээр зэрэг үр төлөө дагуулсан ан амьтныг агнахыг цээрлэж байсан байна.

Энэ талаар XVI зууны эцсээр Монгол газраар аялсан Сяо Да Хэн «Ан авлах нь монголчуудын байнгын үйлс болсон боловч ангийн төрж бойжих, хайрлах ёсыг бас мэднэ. Иймийн тул хавар авлахгүй, зун цуглаж авлахгүй, гагцхүү тав гурваар нийлж арваараа хоршиж бага сага гөрөөлөх болой»² гэж тэмдэглэсэн байдаг.

XVI—XVIII зууны үеийн Монголын хууль цаазын бичигт байгаль орчин, ан амьтныг хэрхэн ашиглаж, хамгаалах талаар нарийн заасан байна. XVI зууны хоёрдугаар хагасын зургаан хошууны хууль цаазын бичигт «... ус буртаглахуул морь, үхэр хоёр ав. Үзсэн гэрч үхэр ав»³ гэж заасан бол хожмын «Халх журам»-д «Мэдэж байж шоглож ус буртаглаваас шүдлэн морь, үхэр хоёрыг ав, үзсэн гэрчид үхэр өг»⁴ гэсэн байдаг. Ан амьтны талаар 1640 оны «Их цааз»-д ангир болжмор албал морь ав. .. булга, үнэг, хэрэм, хярс албал ихээс нь гунж багаас нь хонь ав»⁵ гэж заажээ. «Халх журам»-д хонгор галуу, ангир, нялх янзага, болжмор бүү ал, алсныг хэн хүн үзвээс морь ав⁶ гэсэн нь байгалийн тэнцвэртэй байдлыг алдагдуулахгүйн үүднээс тодорхой нэг хугацаанд эдгээр ан амьтныг агнахыг цаазалсан бололтой. Мөн тарвага утаад ухаж авалгүй орхисон хүнээс шүдлэн үхэр ав⁷ гэх буюу «Зургаан хошууны цааз бичиг»-т Хэн хүн адгуус шаналган алахыг⁸ хоригложээ.

Монголчуудын байгаль хамгаалах уламжлалын нэгэн чухал зүйл бол гал түймрийн аюулаас сэргийлэх явдал байв. 1640 оны «Их цааз»-д ...нүүсэн нутгаас хүн гал унтраавал хонь ав. Өшиж түймэр тавьбал их хэвээр болтугай»⁹ гэж заасан бөгөөд «Зургаан хошууны цааз бичиг»-т түймэр алдсан хүнийг хэн үзсэн хүн нэг морь ав»¹⁰ гэсэн байна. «Халх журам»-д нүүсэн нутагт гарсан галыг хэн үзсэн хүн унтраах, эс унтраагаас шүдлэн морь¹¹ ав гэж заажээ. Үүнээс хожмын хуулинд ч түймэр алдан өвс бэлчээрийг сүйтгэх, хүн мал түлж хохируулахыг цаазалсан байдаг. Энэ мэтчилэн монголчуудын дунд байгаль орчныг хамгаалах үзэл тэдний ахуй байдалтай холбогдон гарч иржээ.

Хууль цаазын бичиг хэрэглэгдэхүүнд байгаль хамгаалах талаар тусгасан зүйл аажмаар нэмэгдэж байгаль түүний баялаг, ашиг шимийн тухай зүйл анги хэрэгцээ шаардлагаар гарч ирж байсан нь өмнөх хуулиудаас харахад тодорхой байна. Дээрх хуулиудад байгаль орчныг хамгаалах хийгээд, зарим ховор амьтдыг дархлажээ.

Монголчуудын байгаль хамгаалах өөр нэг хэлбэр бол эрт үеэс уул ус, ой модоо дархлан тахиж ирсэн явдал юм. Тухайлбал МЭӨ III зуу-

ны үед хүннүчүүд Отгон тэнгэр уулыг тахиж зун, намрын цагт их тайлган хийдэг байжээ.¹² Мөн Хан Хэнтий уулыг тахиж байсан мэдээ XIII зууны үеийн сурвалж бичиг «Монголын нууц товчоо»-нд байдаг. Энэхүү тахилгатай ууланд мод огтлох, ан агнах, газар малтах зэргийг хоригложээ. Манжийн түрэмгийллийн эхэн үед уул, усыг тахиж шүтэх явдал тасарсан байна. Гэвч Санжаадорж, Юндэндорж нарын хүсэлтээр Манжийн хаан зарлиг гарган 1778 оноос Богд хан (Хан Хайрхан), 1779 оноос Отгон тэнгэр, 1818 оноос Хан Хэнтий¹³ уулыг дахин тахиж болсон байна. Үүнээс гадна Халхын хошуу бүхэн өөрийн овоо тахилгатай, жил бүр овооны наадам хийдэг байжээ. Энэ талаар ахмад түүхч Ц. Насанбалжир гадаад хэлбэрээрээ шашин шүтлэг бишрэлийн шинжтэй боловч үнэн байдал, ач холбогдлын хувьд байгаль хамгаалалтын нэг өвөрмөц хэлбэр шинж агуулгыг хадгалж байжээ гээд зөвхөн Дорнод Монголын (одоогийн Хэнтий, Дорнод, Сүхбаатарын зүүн ба хойд зах, Дорно говийн хойд зах, Төв, Дундговийн зүүн зах) нутагт 450 гаруй тахилгатай, уул, ус байх болсон талаар архивын мэдээ баримтанд тулгуурлан бичээд энэ бол байгаль хамгаалах орон нутгийн чанартай зүйл болно гэсэн байна.¹⁴

Манж нар Монгол орны байгалийн баялаг, ховор ан амьтны үсийг үлэмж ихээр зөөвөрлөж байв. Тэрээр Хөвсгөлийн урианхайчуудад тусгай «үст алба»-ыг эрхлүүлэхийн зэрэгцээ жил бүрийн намар анчин, гөрөөчинг цуглуулж «Урамдлын ан»-г зохион байгуулж ан амьтныг их хэмжээгээр агнадаг байв. Монголын ард түмэн байгалийн баялагаа харийн түрэмгийлэгчдэд цөлбүүлэхийг ил, далд, шашны болон янз бүрийн хэлбэрээр эсэргүүцэн тэмцэж байв. Энэ тэмцэл нь гадаадын капи талистуудаас Халхад алтны уурхай нээх гэсэн оролдлого биелүүлэхийг нэлээд хэдэн жил хойш татсан байна.¹⁵

Манай ард түмний байгаль орчноо хамгаалах, түүний унаган төрхийг хэвээр хадгалан залгамжлуулан үлдээсээр ирсэн баялаг туршлагын нэг нь хойч үеэ бага наснаас нь эхлэн тэдний хамгийн дуртай үлгэр, магтаал, туульс, зүйр цэцэн үгээр нь дамжуулан байгалийн гоо үзэмжийг мэдрүүлэх, түүнийг хайрлах хамгаалах сэтгэлийг улам оргилуун болгон, эх нутгаа хүндэтгэн үзэх үзлийг төлөвшүүлэн өгдөг сайхан уламжлалтай байжээ. Тэрчлэн уул, усаа баялаг эрдэнэсээр нь, Ховор ан амьтан, жигүүртэн шувуугаар нь нэрлэж байв.

Дээр өгүүлсэнчлэн Монголын ард түмэн байгаль орчноо хамгаалах, түүний баялагийг ашиглах талаар арвин мэдлэг туршлагатай байсан бөгөөд түүнийгээ амьдрал ахуйдаа хэвшүүлсээр иржээ.

¹ Книга Марко Поло. М., 1955, 123-р тал

² **Сяо Да Хэн.** Монголчуудын зан заншил, Монгол хэл зохиол, түүх. 1960.

№ 2. Өвөрмонголын хэвлэл

³ **Х. Пэрлээ.** Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. УБ., 1974. 82-р тал

⁴ Халха Джирум, М., 1965. 98-р тал

⁵ Их цааз (Великое уложение). Памятник монгольского феодального права XVII в. М., 1981, 52-р тал

⁶ Халха Джирум. М., 1965, 247-р тал

⁷ Халха Джирум. М., 1965. 266-р тал

⁸ **Х. Пэрлээ.** Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг. УБ. 1974 80-р тал

⁹ Их цааз (Великое уложение) Памятник монгольского феодального право XVII в М., 1981. 48-р тал.

¹⁰ Х. Пэрлээ. Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг. УБ., 1974 82-р тал

¹¹ Халха Джирум. М., 1965. 299-р тал

¹² **А. Очир.** Эртний монголчуудын цаг тооллын мэдлэгийг сарын нэрээр мөшгөх нь. «Этнографийн судлал» сэтгүүл, УБ., 1985. 17-р тал

¹³ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. (баримт бичгийн эмхтгэл, эмхтгэсэн А. Очир, Г. Пүрвээ, 306—307-р тал)

¹⁴ **Ц. Насанбалжир.** Монголчуудын байгаль ба байгаль орчны уламжлалт хамгаалалтын тухай, ОУМЭ-ний III их хурал. III боть, 1979. 216-р тал

¹⁵ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. (баримт бичгийн эмхтгэл) Эмхтгэсэн А. Очир, Г. Пүрвээ. УБ., 1982, 8, 10, 41, 42-р тал

**СОЦИАЛИСТ ЧИГ
БАРИМЖААТ ОРНУУД:
ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ
ХАНГАМЖИЙН БАЙДАЛ,
ТӨЛӨВ**

Ц. БААТАР

Социалист чиг баримжаат орнуудын эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй юм. Дотоодын нийт бүтээгдэхүүний 50 орчим хувь, экспортын 80—90 хувийг энэ салбар гаргана. Хүн амын 70—80 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж амьдарч байна. Энэ орнуудад хөдөө аж ахуйн хоцрогдлыг гэтлэн давах, хүнсний асуудлыг шийдвэрлэх нь өнөөдөр туйлын бэрхшээлтэй асуудал болоод байна.

Эдийн засгийн үзэгдлийн хувьд хүнсний асуудал нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээн дэх үйлдвэрлэх хүчний хөгжил, хүн амын өсөлт, нийгмийн хөгжлөөр нөхцөлдсөн олон хүчин зүйл (дотоод, гадаад) -ээс шалтгаална. Хөгжиж байгаа орны хөдөө аж ахуйн хоцрогдол, хүнсний асуудал эцсийн бүлэгт капиталист үйлдвэрлэлийн аргаас, түүний шулан мөлжиж ирсэн өнгөрсөн, өнөөгийн түрэмгий бодлогын уршигт үр дагавар юм.

Тодруулж хэлбэл хүрээлэн буй орчныг ихээхэн бохирдуулдаг үйлдвэрлэлийн төрлийг олон улсын монополиуд эдгээр оронд шилжүүлснээс болж экологийн асуудал хурцдаж аж ахуйн алдагдал улам ихсэв. Тухайлбал, дээрх оронд байгалиар нөхөн сэргээдэг нөөц-өнгөн хөрс устаж тариалангийн талбай, малын бэлчээр хужиртах, элсэнд идэгдэж цөлжих хандлага газар авч сөрөг үзэгдэл их гарч байна. Зарим үнэлгээнээс үзэхэд таримлын ургацын 40 хувь нь хөдөө аж